

СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.САЙХАНЖАРГАЛЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэ дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. “Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт”							
1.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-г хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж тайлан мэдээг хуулийн хугацаанд стандартын дагуу гаргаж, нэгтгэн тайлагнаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрд хугацаанд нь биелүүлэн ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар нийт Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан болон бусад чиглэлээр нийт 179 бичиг ирүүлснээс 1 дүрэм, 5 журам, 4 тогтоол, 16 тушаал, 9 шийдвэр, 18 заавар, зөвлөмж, 1 аргачлал, чиглэл, 13 судалгаа, тайлан ирүүлэх, 8 санал, 28 чиглэл, 5 мэдээлэл ирүүлэх тухай, 13 сургалтад хамруулах тухай, 60 бусад чиглэлээр ирсэн байна. Үүнээс сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэнд хамаарах газрын даргын болон хэлтсийн даргын	08.15 - 12.03	98

					шилжүүлсэн албан бичгүүдийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж, тайлагнан, үр дүнг тухай бүрд тооцон ажиллаж байна.		
Зорилт 4. “4 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт”							
1.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын газруудад НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна.	Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Тогтоол шийдвэр, албан даалгаврын хүрээнд Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, төлөвлөгөөний биелэлт, Дүүргийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Газрын бичмэл тайлан 3 дугаар улирлын болон жилийн эцсээр, НДЕГ-аас ирүүлсэн А/138 дугаар тушаалаар “Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г батлан хүргүүлж, төлөвлөгөөний дагуу биелэлтийг 14 хоног тутамд гаргаж, НДЕГ-ын ЗУГ-т хүргүүлж, газрын сургалт сурталчилгааны тайлан 3 дугаар улирал болон жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, тухай бүрд газрын даргад танилцуулан, хянуулан дээд газарт хүргүүлэн ажиллаж байна. Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэр, албан даалгаврын биелэлт болон Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.	08.15 - 12.03	95
2.	Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх	Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг			Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан Нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэд даатгуулагч, ажил олгогч нарт газрын албан ёсны фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, нийгмийн даатгалын ажил		

		хэрэгжүүлсэн байна.	Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх.	Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор шинээр санаачлан мэдээлэл байршуулах ажлын хуваарь гарган газрын даргаар хянан баталгаажуулж, хуваарийн дагуу Хамралт орлогын хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Хайлааст тасаг, Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсүүдээс бэлтгэсэн 13 удаагийн мэдээллийг байршуулан ажилласан байна. Байгууллагын дотоод үйл ажиллагаа болон ажилтан албан хаагчдын идэвхжүүлэлт, ажлын байрны тав тух, хамт олны эерэг уур амьсгалыг бэхжүүлэх, шинэ санал санаачилгыг эрэлхийлэн дэмжих, харилцан биеэ хүндэтгэж, хайрлах сэдлийг бий болгон байгууллагын хэмжээнд ажилтан албан хаагч, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулж, хуваарийн дагуу багууд 7 хоног бүрийн эхний өдрийг өглөөний цай бэлтгэж бусдыгаа дайлах, ажлын сүүлийн өдрийг хамт олныг урамшуулсан мэндчилгээ, талархал илэрхийлэх, эрч хүч хайрлах өдөр болгон амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Ажилтан албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, эрүүл мэнд идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, гар бөмбөгийн спортыг дэмжих зорилгоор спортын арга хэмжээ зохион байгуулах удирдамж боловсруулан газрын даргаар батлуулж, газрын ажилтан албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж, I,II,III дугаар байр, шилдэг тоглогчийг шалгаруулан цом, өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.	08.15 - 12.03	100
--	--	---------------------	---	---	--	------------------	-----

					Газрын хэмжээнд Нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, аян зохион байгуулах, нээлттэй хаалганы өдөрлөг, явуулын үйлчилгээ зохион байгуулахад ашиглах 6-н төрлийн баннерыг шинэчлэн эх бэлтгэлийг хийж, хамтран ажилладаг хэвлэлийн компанид захиалга өгч хийлгэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг ажил олгогч, иргэд даатгуулагч нарт түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж, мэдээлэл авах сувгийг нэмэгдүүлэх зорилгоор албан ёсны фэйсбүүк хуудасны мессенжерт "ЧАТБОТ"-үйлчилгээг холбон нэвтрүүллээ. Ажил олгогч, иргэд даатгуулагч нар өөрт хэрэгцээт мэдээ мэдээллээ газрын чатбот үйлчилгээнд холбогдож авах бүрэн боломжийг бүрдүүлэн ажилласан.		
3.	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;	Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 41 удаагийн сургалтад 46 албан хаагчийг хамруулсан.	-Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 15 удаагийн сургалтад 294 албан хаагчийг давхардсан тоогоор хамруулсан. Албан хаагчдад зориулсан дотоод болон гадаад сургалтад хамруулах төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу сургалт сурталчилгааг зохион байгуулахад хэлтсийн дарга байцаагч ажилтнууд болон холбогдох байгууллагуудад хүсэлт илгээж, сургалт авах болон тухайн байгууллагад очиж танхимаар сургалтад хамруулах хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна. Сургалтын төлөвлөгөөний дагуу дараах сургалтууд зохион байгуулж, мөн бусад газраас зохион байгуулсан сургалтуудад холбогдох ажилтан албан хаагч нарыг тухай бүрд хамруулан ажиллалаа. Ажилтан албан хаагч нарт "Авлигын эсрэг хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд 2024	08.15 - 12.03	

				-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ.	оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Нийслэлийн прокурорын газартай хамтран сургалт зохион байгууллаа. Чингэлтэй дүүргийн насан туршийн суралцахуйн төвөөс " Хувь хүний харилцааны чадвар, Хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх нь" сэдэвт сургалтыг авч тухайн газартай хамтран ажиллалаа. 10 дугаар сард Төрийн албаны зөвлөлөөс, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран "Пүрэв" гараг бүр зохион байгуулдаг ээлжит "7:4:10" вебинар 6 удаагийн сургалтад ажилтан албан хаагч нарыг онлайнаар хамруулан ажиллалаа.Холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан 7 удаагийн сургалтад ажилтан албан хаагч нар танхимаар оролцлоо.		95
4.	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах;	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 52 удаагийн сургалтад 19653 иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.	Ажил олгогч, иргэд даатгуулагч, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын ач холбогдлыг таниулан сурталчлах чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн хамтарсан "БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ-ХАМТЫН АЖИЛЛАГАА" Ажил олгогчдын зөвлөгөөн 2024 амжилттай зохион байгуулагдаж, тус зөвлөгөөнд Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга, Хяналт шалгалтын улсын байцаагч, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн нар оролцож, ажил олгогчдод Нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, үйл ажиллагааны талаар арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Тус газар нь Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй хамтран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч	08.15 - 12.03	100

					иргэд даатгуулагчдад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчлэл, тэтгэвэр, тэтгэмж цахим үйлчилгээний талаар мэдээ мэдээлэл хүргэх, Нийгмийн даатгалын ойлголтыг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд ээлжит сургалтыг 2024.09.05-ны өдөр танхимаар зохион байгуулж ажилласан. 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр М-Си -Эс Кока Кола ХХК-ийн ажилтан албан хаагчдад дараах сэдвийн хүрээнд ээлжит сургалтыг танхимаар зохион байгууллаа. Үүнд: Нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлт, Тэтгэврийн сангийн хуримтлал, Нийгмийн даатгал төлснөөрөө даатгуулагчдын хүртэх үр өгөөж, Шимтгэл суутгалын төлөх хувь хэмжээ, Нийгмийн даатгалын бодолт, Ажилгүйдлийн тэтгэмж, Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн талаар мөн ажилтан албан хаагчдын асуултад хариулж хэрэгцээт мэдээллийг өгч ажиллалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласантай холбогдуулан НДЕГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу тус газар нь Улсын их дэлгүүрийн 1 давхарт ажил олгогч, иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, ажил үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг” 10:00-16:00 цагийн хооронд нийт 309 иргэнд хүрч, арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Үүнд: - Ажил олгогч, даатгуулагч иргэдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг таниулах, шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө, мэдээлэл өгөх асуудлаар нийт 309 иргэн		
--	--	--	--	--	--	--	--

					- Иргэдэд нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдахын ач холбогдлыг таниулах, сайн дурын даатгалд хэн хамрагдах боломжтой болох талаар дэлгэрэнгүй мэдээлэл зөвлөгөөг 58 иргэн - Өдөрлөгийн үеэр иргэдийг сайн дураар сайн дурын даатгалд шинээр хамруулах, гэрээ байгуулах, гэрээ сунгах, шимтгэл төлөлт хийлгэх үйлчилгээнд 31 иргэн - Тэтгэвэр, тэтгэмж тогтоох, шимтгэл төлж ажилласан хугацаа тооцох, хүсэлтийг цахимаар илгээж болох зэрэг иргэдийн авахыг хүссэн мэдээллээр асуусан асуултад бүрэн мэдээллийг 123 иргэн -Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл 42 иргэн -Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зарлал, мэдээллийг газрын албан ёсны фэйсбүүкээр олон удаагийн давтамжаар байршуулан мэдээллийг ажилтан албан хаагч нар116 удаагийн давтамжаар шэйр хийж, мөн өдөрлөг зохион байгуулагдах газрын гадна дэлгэцээр 15 минут тутамд видео мэдээллийг түгээж, дотор талбайд цагаан хоолойгоор 1 цаг тутамд зарлал хүргэсэн - Өдөрлөгт үйлчилгээ, мэдээлэл, зөвлөгөө авсан нийт 219 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. - Өдөрлөгийн үеэр нийт 42 иргэний гар утсанд Нийгмийн даатгалын аппликейшний 2.0 хувилбарыг татаж, суулган өгч арга хэмжээг амжилттай зохион байгуулж, ажиллалаа. 9 дүгээр сарыг "Нээлттэй мэдээллийн сар" болгон зарласантай холбогдуулан тус газар нь 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ажил олгогчийн ээлжит сургалтыг МонЦаМэ агентлагийн ажилтан албан хаагчдад Нийгмийн даатгалын багц хуулийг		
--	--	--	--	--	---	--	--

					сурталчлан таниулах, тэтгэвэр, тэтгэмж, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн ач холбогдлын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Ажил олгогч, иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, Нийгмийн даатгалын тухай хуулийн талаарх ойлголт, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулдаг ээлжит сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ын ажилтан албан хаагчдад явууллаа. Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд хамтран ажиллах санамж бичиг, арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллах чиглэлийн дагуу тус газар нь 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хилийн цэргийн 0208 дугаар тусгай салбарын ажилтан албан хаагч нарт Нийгмийн даатгалын тухай хууль, цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, нийгмийн даатгалын тайлан илгээхэд анхаарах асуудлууд сэдвээр сургалт өгч, мэдээ мэдээллийг хүргэж ажиллалаа.		
--	--	--	--	--	--	--	--

5.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн 55 тоо, мэдээллийн төрөл 18863	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор газрын албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол 64 мэдээ мэдээллийг пастороор байршуулан хүргэж, батлагдсан хуваарийн дагуу сар бүр шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. 2024 оны IV улирлын байдлаар нийт 6 удаа шууд Live хийж, 13800 гаруй иргэд даатгуулагчид үзсэн хандалттай байна. Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор газрын албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, батлагдсан хуваарийн дагуу сар бүр шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна. Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д нийт 64 мэдээллийг тогтмол байршуулан 1800 гаруй иргэд	08.15 - 12.03	98
----	--	---	--	---	----------------------	----

		бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл.			даатгуулагчдын хандалт авч, 700 гаруй шэйр хийж түгээсэн байна. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн 9 удаагийн сургалт сурталчилгааг зохион байгуулан мөн Ажил олгогчийн зөвлөгөөн, Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан ажил тус бүрийг тухай бүрд газрын албан ёсны фэйсбүүк, пэйж хуудсаар нийтлэн иргэд, даатгуулагчдад мэдээлэн ажилласан байна.		
--	--	---	--	--	--	--	--

Зорилт 5. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнах, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгжийн дарга, албан тушаалтанд хүргүүлэх;	Үйл ажиллагааны явц, хэрэгжилтийн байдлаар	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр хийж гүйцэтгэх.	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг бүтэн жилээр хийж гүйцэтгэх.	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж, төлөвлөгөөний биелэлтийг улирал бүрээр нэгтгэж, тайлагнан ажиллаж байна. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хуулийн хугацаанд нь гаргаж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнах, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгжийн дарга, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан байна. Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.	08.15 - 12.03	95
----	---	--	--	--	---	---------------	----

2.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллах, хэрэгжилтийг хангах	Шийдвэрлэсэн албан бичиг, үр дүн, үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлаар	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллах, албан хэрэгт хөтлөгдөж дууссан анхан шатны баримтыг хуулийн хугацаанд архивт хүлээлгэх өгөх	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллах	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу 2024 оны архивд шилжүүлэх баримтуудыг хуулийн хугацаанд акт үйлдэн архивд шилжүүлэн ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг түргэн шуурхай биелүүлэн ажиллаж байна.	08.15 - 12.03	90
3.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, гомдол саналгүй ажиллах	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, түүний шийдвэрлэлтийн хувиар	Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, гомдол саналгүй ажиллах	Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, гомдол саналгүй ажиллах	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2024 оны IV улирлын байдлаар гомдол саналгүй ажилласан.	08.15 - 12.03	90
4.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй	Иргэдээс ирүүлсэн гомдол санал, ажлын үр дүн, хэрэгжилтийн хувиар,	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулж, ашиг сонирхлын	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулж, ашиг сонирхлын	Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ажилтан, албан хаагчийг урьдчилан сэргийлэх, авлигаас ангид хамт олон байх, авлига ашиг сонирхлын зөрчлийн гэмт хэрэгт холбогдохгүй байх тал дээр анхаарч ажилтан албан хаагч нарт "Авлигын эсрэг хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Нийслэлийн	08.15 - 12.03	90

	нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авилга ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах		зөрчлөөс урьдчилан сэргийлж тухайн хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авилга ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах	зөрчлөөс урьдчилан сэргийлж тухайн хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авилга ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах	прокурорын газартай хамтран сургалт зохион байгууллаа. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газар нь байгууллагын болон албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Газрын болон Хайлааст дахь газрын нэг давхрын угтах үйлчилгээний үүдэнд "ДААТГУУЛАГЧ ТА АВЛИГАГҮЙ БҮСЭД НЭВТЭРЛЭЭ" ухуулга самбар, газрын албан ёсны фэйсбүүк хуудсаар иргэд даатгуулагчдад Авлигагүй, эрүүл аюулгүй нийгмийг цогцлооход таны оролцоо чухал" гэсэн уриалга бүхий пасторыг олон давтамжаар байршуулан ажилласан.		
--	---	--	---	---	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
-----	-------------------------------	------------------	--------------	--------------	-------------------------	-------------------------	-----------------

1.	Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх	Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх.	Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан Нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэд даатгуулагч, ажил олгогч нарт газрын албан ёсны фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор шинээр санаачлан мэдээлэл байршуулах ажлын хуваарь гарган газрын даргаар хянан баталгаажуулж, хуваарийн дагуу Хамралт орлогын хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Хайлааст тасаг, Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсүүдээс бэлтгэсэн 13 удаагийн мэдээллийг байршуулан ажилласан байна. Байгууллагын дотоод үйл ажиллагаа болон ажилтан албан хаагчдын идэвхжүүлэлт, ажлын байрны тав тух, хамт олны эерэг уур амьсгалыг бэхжүүлэх, шинэ санал санаачилгыг эрэлхийлэн дэмжих, харилцан биеэ хүндэтгэж, хайрлах сэдлийг бий болгон байгууллагын хэмжээнд ажилтан албан хаагч, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулж, хуваарийн дагуу багууд 7 хоног бүрийн эхний өдрийг өглөөний цай бэлтгэж бусдыгаа дайлах, ажлын сүүлийн өдрийг хамт олныг урамшуулсан мэндчилгээ, талархал илэрхийлэх, эрч хүч хайрлах өдөр болгон амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Ажилтан албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, эрүүл мэнд идэвхтэй хөдөлгөөнийг	08.15 - 12.03	100
----	---	---	---	---	--	------------------	-----

					дэмжих, гар бөмбөгийн спортыг дэмжих зорилгоор спортын арга хэмжээ зохион байгуулах удирдамж боловсруулан газрын даргаар батлуулж, газрын ажилтан албан хаагчдын дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж, I,II,III дугаар байр, шилдэг тоглогчийг шалгаруулан цом, өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. Газрын хэмжээнд Нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, аян зохион байгуулах, нээлттэй хаалганы өдөрлөг, явуулын үйлчилгээ зохион байгуулахад ашиглах 6-н төрлийн баннерыг шинэчлэн эх бэлтгэлийг хийж, хамтран ажилладаг хэвлэлийн компанид захиалга өгч хийлгэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг ажил олгогч, иргэд даатгуулагч нарт түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж, мэдээлэл авах сувгийг нэмэгдүүлэх зорилгоор албан ёсны фэйсбүүк хуудасны мессенжерт "ЧАТБОТ"-үйлчилгээг холбон нэвтрүүллээ. Ажил олгогч, иргэд даатгуулагч нар өөрт хэрэгцээт мэдээ мэдээллээ газрын чатбот үйлчилгээнд холбогдож авах бүрэн боломжийг бүрдүүлэн ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээш түвшинд барилдана								
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7

1.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийг судлах	Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар цогц мэдлэг эзэмшсэн байна	Хуулийн цогц мэдлэг мэдээлэл авах	Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлтүүд, шинээр хэрэгжиж байгаа хуулийн зохицуулалтуудын талаар цогц мэдлэг эзэмших, мэргэшсэн чадварлаг албан хаагч болох	Жилийн эцсийн байдлаар нийт Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан болон бусад чиглэлээр нийт 179 бичиг ирүүлснээс 1 дүрэм, 5 журам, 4 тогтоол, 16 тушаал, 9 шийдвэр, 18 заавар, зөвлөмж, 1 аргачлал, чиглэл, 13 судалгаа, тайлан ирүүлэх, 8 санал, 28 чиглэл, 5 мэдээлэл ирүүлэх тухай, 13 сургалтад хамруулах тухай, 60 бусад чиглэлээр ирсэн байна. Үүнээс сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэнд хамаарах газрын даргын болон хэлтсийн даргын шилжүүлсэн албан бичгүүдийн хэрэгжилтийг ханган, үр дүнг тухай бүрд тооцон ажиллаж байна..	08.15 - 12.03	90
2.	Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамрагдах	Монгол бичгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах эзэмших	Монгол бичгийн анхан дунд шатны мэдлэг мэдээлэл авах	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасны дагуу богино болон дунд хугацааны сургалтад цахимаар хамрагдаж, Монгол бичгийн анхан дунд шатны цахим сургалтад хамрагдаж албан хэрэглээний түвшинд эзэмшсэн байна	Монгол бичгийн анхан болон дунд шатны хичээлийг боловсруулан 2025 оны сургалтын төлөвлөгөөнд тусган ажилтан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, анхан шатны мэдлэг эзэмшүүлэх тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.	08.15 - 12.03	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалт сурталчилгаа хариуцсан
мэргэжилтэн
(Албан тушаал)

Т. Сайханжаргал / Т. Сайханжаргал. /
(Нэр, гарын үсэг)

2024 12 03
(Огноо)